

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
М.СОНОМПИЛ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт Австрийн экспортын санхүүжилтийн системийн дэмжлэгтэйгээр олгогдсон албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах гаалийн албан татвараас чөлөөлөх асуудал нь хэлэлцээрийн хүрээнд зохицуулагдаагүй бөгөөд эдгээр төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төслийн үр ашгийг хангах зорилгоор төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материалыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр хуулийн төслийг боловсруулсан байна.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Сономпил, Ч.Улаан нар төслийг хэлэлцэхийг дэмжиж байна, хөнгөлөлттэй зээлийн төслүүдийг шуурхай хэрэгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй гэсэн саналуудыг гаргасан болно.


Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Төсвийн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.БОЛОР**